

**ГАДААДЫН ИРГЭН,ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН
НЭГЖ БАЙГУУЛЛАГАД ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

2015 оны 11 сарын 18 өдөр

№71

Айраг сум

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, **Дорноговь** аймаг /нийслэл/-ийн **Айраг** сум /дүүрэг/-ын Засаг даргын **2015 оны 06-р** сарын **19-ны** өдрийн **А/70** тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж **Айраг** сум /дүүрэг/-ын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан **Тэгшдэлгэр** овогтой **Золбоо** газар ашиглагчийг төлөөлж, **"Экилешия"ХХК-ны захирал /** ажилтай **Сумъяабазар** овогтой **Бурмаа** нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ _____ /га/. Үүнээс:
Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт _____ ухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ
Жонш олборлох зориулалтаар **38,41 км**

2.2 Газрын төлбөрийн хэмжээ
Нэгжийн үнэ **16000** төгрөг /үсгээр _____ **Арван зургаан мянган төгрөг** /
Бүгд үнэ **614560** төгрөг /үсгээр -- _____ **Зургаан зуун арван дөрвөн мянга таван зуун жаран төгрөг** /
Үүнээс
улиралд _____ төг улиралд **614560** төг
улиралд _____ төг улиралд _____ төг

2.3 Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн **ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН САН** **БАНКНЫ 060000943** тоот дансанд шилжүүлж байна.

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тооцно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг

3.1. гэрээний нөхцөлийн дагуу газрыг ашиглах;

3.2. газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглуулахаар гэрчилгээний хугацааг сунгуулах;

3.5. газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;

3.6. төлбөрийг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хоног тутам алданги төлөх;

3.7. ашигласан газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;

3.8. газар ашиглуулагчаас газрын эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;

3.9. холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

4.1. газар ашиглагч газрыг гэрээний дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах;

4.2. уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:

Орчныг бохирдлоос сэргийлэх арга хэмжээг газар эзэмшигч өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ. Зохих зөвшөөрөлгүйгээр газрыг хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртлэх арга хэмжээ авна. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд газар эзэмших эрх хүчингүй болно. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлана.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

4.3. газрыг гэрээний нөхцлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу "Газрын тухай" хуулийн 40.1.1.- 40.1.6. дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

4.4. газар эзэмших гэрээг жил бүр дүгнэх;

4.5. холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. Газар эзэмшигчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **Газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.

5.2. Газар эзэмших эрх болон гэрээний хугацаа дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай анх эрх олгосон шийдвэрт заасан бол тэр дагуу, харин заагаагүй бол **Газар эзэмших гэрээний хугацаа дуусгавар болмогц газар эзэмших гэрээг цуцалж баригдсан барилга байгууламжийг газар эзэмшиж байсан аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр чөлөөлнө** гэж шийдвэрлэнэ.

5.3. Энэхүү гэрээгээр эзэмших эзэмшил газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48 дугаар зүйлийн дагуу зохицуулах** болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.4. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

5.5. Гэрээний талууд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл:

Газрын төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг хүчингүй болгож, газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Газар эзэмших эрх болон гэрээний хугацааг сунгулахын тулд тухайн эрх дуусахад нэг сарын өмнө Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан баримт бичгүүдийг бүрдүүлэн газрын албанд хүсэлтээ гаргана. Хэрэв тухайн хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй бол газар эзэмших эрх дуусгавар болно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн **Нэг** /үсгээр/ жилийн хугацаатай байгуулав.

6.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Айраг сумын Засаг Даргын Тамгын Газар

Газар эзэмшүүлэгч:

Утас: 4154

"Экилешия" ХХК

Газар ашиглагч:

Регистр /улсын бүртгэл/- ийн дугаар


Харилцах дансны дугаар
ЭХарилцах утас_91997204

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглагчийг төлөөлж: **"Экилешия" ХХК-ны
Захирал С.Бурмаа**

**Дорноговь аймаг/нийслэл/-ын Айраг сум
газрын асуудал эрхэлсэн албан
тушаалтан Тэгшдэлгэр овогтой Золбоо**

/гарын үсэг/



/тамга/



/гарын үсэг/

/тамга/

Энэхүү гэрээний нэг хувийг тоот дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.